

БАТЛАВ:

МОНГОЛРОСЦВЕТМЕТ ТӨҮГ-ЫН

БОР-ӨНДӨР УБУ-ИЙН ЗАХИРАЛ

Б.МАГСАРЖАВ

“ 2022 оны “ ” дугаар сарын “ ”

УБУ-ийн техникийн нөхцөл олгох комиссын  
2022 оны 09-р сарын 14-ний өдрийн хурлын 22/06  
тоот протоколыг үндэслэн зөвшөөрөв

ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ №22/6

1.	Барилга байгууламжийн мэдээлэл:	Бор-Өндөр УБУ-ийн 36 айлын орон сууцны дахин төлөвлөлт
2.	Барилга байгууламжийн байршил:	Хэнтий аймаг, Бор-Өндөр сум, холбоо 2-р баг, Их тойруу-3, 313А тоот. №46 байрны зүүн урд талд
3.	Нийт усны хэрэглээ:	Нийт цэвэр усны - 2,60 м <sup>3</sup> /хоног Үүнээс: Хүйтэн усны - 1,60 м <sup>3</sup> /хоног Халуун усны - 1,03 м <sup>3</sup> /хоног Галын усны - 0,5 л/с
4.	Нийт дулааны хэрэглээ:	Нийт - 0,21 Гкал/цаг Үүнээс: Халаалт - 0,17 Гкал/цаг Халуун ус - 0,03 Гкал/цаг Салхилуулаг - 0 Гкал/цаг
5.	Цахилгаан, цэвэр ус, дулааны холболт хийх цэгийн байршил, шугамын диаметр:	Нэмэлт нөхцөл, тавигдах шаардлагыг хангасан тохиолдолд: Дулаан, ус хангамжийг №46-р байрны хонгил дамжсан түгээх шугамын төгсгөлөөс үргэлжлүүлэн баригдах байрны хонгилоор үргэлжлүүлнэ. Дулаан 2x159 ган хоолой, Хэрэглээний хүйтэн ус 1x100 цайрдсан ган хоолой, Халуун ус 1x76, 1x50 цайрдсан ган хоолой байх ба эдгээр байрны орчны анхдагч узельд холбогдоно.
6.	Шугамын даралт, температур:	A. Хоболтын цэг дээр байх түрэлт - B. Шугамын статик даралт - C. Буцах шугамын даралт - D. Гадна агаарын тооцоот температур -28,3 °C E. Температурын гафик 90/65 °C
7.	Бохир усны холболт хийх цэгийн байршил, шугамын диаметр:	Ариутгах татуургыг баригдах байрны зүүн хойш 9м зайд орших УБУ-ээс ирж буй ариутгах татуургын шугам №17 худагт салбарлан холбоно.
8.	Нэмэлт нөхцөл:	<b>Бусад шаардлага:</b> 1. Ус хангамж, дулааны болон ариутгах татуургын шугамыг барихдаа трассын дагуух тохижилт, нөхөн сэргээх ажлыг төлөвлөхдөө инженерийн шугам, түүний хамгаалалтын зурвасыг тооцож, засвар үйлчилгээ хийх нөхцөлийг бүрдүүлж хангагч байгууллагаас зөвшөөрөл авах. 2. Объектын талбай дамжсан инженерийн шугамуудыг шинэчлэх болон гадна дулаан хангамжийн систем, узель ба дотор системийн угаалт, шахалтын туршилт хийх зардлыг төсөвт тусгах. 3. Барилгын гадна шугам сүлжээний холбох цэгийг өөрчлөх тохиолдолд хүсэлт тавьж хянуулан, хангагч байгууллагын зөвшөөрлөөр гүйцэтгэнэ. 4. Холбогдох Хууль, БНБД, стандартыг мөрдөх 5. Гадна шугамын ажлын зургийг хотын ерөнхий төлөвлөгөөтэй зөвшилцөх 6. Төлөвлөж буй барилгад төвлөрсөн дулаан хангамжийн техник

		<p>ашиглалтын шаардлага хангасан холигч насосын узель суурилуулж болох.</p> <p>7. Гадна ус, дулааны шугам болон узелийн тоноглолыг дулааны алдагдлын норм нормативд нийцсэн материалаар техник ашиглалтын шаардлагын дагуу дулаалахаар зураг төсөвт тусгах</p> <p>8. Шинээр худаг гаргах шугам далдалж өргөтгөх ажлын зураг, ажил гүйцэтгэлийн зардлыг барилгын зураг төсөвт багтаан төсөвт тусгуулж, гүйцэтгэх.</p>
9.	<b>Тавигдах шаардлага:</b>	<p>1. Барилгыг “Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай” хуулийн дагуу цэвэр усны шугамын тэнхлэгээс 5м, бохир усны шугамын тэнхлэгээс 6 метр, “Эрчим хүчний тухай хууль”-ийн 33 дугаар зүйл, “Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм”-ийн 1.3 дах заалтыг мөрдөж цахилгаан дамжуулах шугамын захаас 5 метр зайд барих.</p> <p>2. Шугамын хамгаалалтын зурваст тохижилт, зам талбай, зогсоол, бусад байгууламж төлөвлөхгүй байх.</p> <p>3. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 15.1.10 –ын болон “Эрчим хүчний тухай хууль”-ийн 30 дугаар зүйлийн 30.1.10; 29 дүгээр зүйлийн 29.1.9 дэх заалтыг мөрдөж хангагч нь хэрэглэгчийн шугамаас дамжуулан шинээр хэрэглэгч холбох техникийн нөхцөл олгосон тохиолдолд батлагдсан ажлын зураг, төслийн дагуу дараагийн хэрэглэгчийг холбуулах.</p> <p>4. Шугамын трасс сонголт, холболтыг хийхдээ салаа шугам эзэмшигч байгууллага, шугамын трасс дагуух газар эзэмшигч аж ахуй нэгж байгууллага, иргэдтэй урьдчилан зөвшөөрөлцох, бусдын эзэмшил газар шугамын трассыг сонгохгүй байх.</p> <p>5. Дулааны ачааллыг тооцож өгөгдсөн хэмжээнээс хэтрүүлэхгүй байх, өргөтгөлийн барилга нэмж барихгүй байх.</p> <p>6. Ус бага зарцуулах тоног төхөөрөмж, баталгаат тоолуур, шүүр суурилуулах</p> <p>7. Цэвэр, бохир усны шугамын угсралт, шахалт туршилт, холболтын ажлын явцад ашиглалтын байгууллагын хяналтын инженерийг байлцуулж ил, далд ажлын акт хөтөлнө.</p>
10.	<b>Объект барих дээд газрын шийдвэр:</b>	Кадастрын муж:0220 нэгж талбарын дугаар 2322003563, эзэмших эрх
11.	<b>Архивт бүрдүүлэх материал:</b>	Бор-Өндөрийн УБҮ-ээр хянаж баталгаажуулсан гадна ус хангамж, дулааны шугамын зураг
12.	<b>Техникийн нөхцлийн хүчинтэй хугацаа:</b>	Энэхүү техникийн нөхцөл олгогдсоноос хойш 2 жилийн хугацаанд хүчинтэй байна.
13.	<b>Техникийн нөхцлийг хүчингүй болгох тохиолдол:</b>	<p>1. Техникийн нөхцөлийн аль нэг заалтыг биелүүлээгүй.</p> <p>2. Техникийн нөхцөлийн хугацаа дууссан.</p> <p>3. Техникийн нөхцөлийн аяалал 10 аас дээш хувиар өөрчлөгдсөн.</p>
14.	<b>Хэрэглэгчийн нэр, утас:</b>	Бор-Өндөр УБҮ, Утас:70567508 Имайл: borundur.ubu@gmail.com

ХЯНАСАН:

УБҮ-ИЙН ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР

БОЛОВСРУУЛСАН:

УБҮ-ИЙН ЕРӨНХИЙ ЭРЧИМ ЗҮЙЧ Ү.Г

П.МАШБАТ

Ц.ОЮУНБИЛЭГ

2022-1-13